

БАТЛАВ

“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН
САЛБАРЫН ЗАХИРАЛ



О.САНСАР



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН НУТАГ ДАХ “НҮҮРС
БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ХАЯГДЛЫН ТАЛБАЙ ТӨСӨЛ”-ИЙН
2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5435528

ХЯНАСАН:

“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН
САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГА

Б.БАТСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:

“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН
САЛБАРЫН БАЙГАЛЬ ОРЧИН, УСНЫ
БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.БАТСАЙХАН

Агуулга

ОРШИЛ.....	1
1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	1
1.1 Нүүрс баяжуулах үйлдвэрийн ажиллах горим, хүчин чадал.....	1
1.2 Үйлдвэрийн 2026 оны төлөвлөгөө	1
1.3 Баяжуулах үйлдвэрийн усны зарцуулалт	1
1.4 Технологийн хаягдлын хэмжээ.....	2
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
2.1 Уур амьсгал.....	2
2.2 Геоморфологи	2
2.3 Хөрсөн бүрхэвч	3
2.4 Ургамлан нөмрөг.....	3
2.5 Нийгэм, эдийн засаг	3
2.6 Төслийн талбайн байршил.....	4
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	4
3.1 Эрсдэлийн үнэлгээг эрсдэлийн матриц	5
3.2 Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	7
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	1
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	2
6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	4
7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	4
8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	8
9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	9
10. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	10
11. НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	10
12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨВ	11

ОРШИЛ

Монгол Улсын Их Хурлаас 2015 онд баталсан “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”, Улсын Их Хурлын 2010 оны “Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай” 39 дүгээр тогтоол, 2018 оны “Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 73 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газраас 2019 онд баталсан “Хүнд үйлдвэрийн хөгжлийн үндэсний хөтөлбөр”, мөн Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас 2019 онд баталсан “Хүнд үйлдвэрийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоол, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 41 тоот тогтоолоор батлагдсан 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Гүйцэтгэх захирлын 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/455 тоот тушаалаар байгуулагдсан “Нүүрс баяжуулах үйлдвэр”-ийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд, Тавантолгойн ордыг түшиглэн үйлдвэрлэл, технологийн парк байгуулах төсөл, “Нүүрсний баяжуулах үйлдвэрийн тэжээлийн нүүрсний тээврийн конвейер, бутлуур, ачилтын байгууламжийн барилга угсралтын ажил” төсөлд үндэслэн шинэ, дэвшилтэт болон өндөр технологи, дамжуулах, нутагшуулах болон нэмүү өртөг шингэсэн, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон байгаль орчны нөлөөллийг бууруулахад ач холбогдолтой юм.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаал болон бусад Монгол улсын хууль, журам, тогтоолын шаардлагад нийцүүлэн боловсруулсан.

Компани ISO 14001:2015 байгаль орчны удирдлагын тогтолцоог нэвтрүүлснээр байгаль орчны асуудлуудыг албан ёсоор тодорхойлж тэдгээрийг шийдвэрлэх шат дараатай алхмуудыг бодлогын баримт бичигт тусгасан.

Эдгээр стандарт шаардлага, төлөвлөлт, хариуцлагын хүрээнд 2026 онд хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж тус тус төлөвлөгөөнд тусгав.

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Нүүрс баяжуулах үйлдвэрийн ажиллах горим, хүчин чадал

Нүүрс баяжуулах үйлдвэр /НБҮ/ нь тасралтгүй ажиллагаатай, долоо хоногийн 6 өдөр 12 цагаар 2 ээлжээр ажиллах бөгөөд баяжуулах үйлдвэр нь 7 хоногт 1 удаа төлөвлөгөөт зогсолт хийж, засвар үйлчилгээ явуулдаг. НБҮ нь эхний 1 модулийн туршилт тохируулгын ажлыг 2024 оны 10 сард эхлүүлсэн ба 2024-2025 онд 1.71 сая тонн нүүрс баяжуулсан. 2026 онд 7.5 сая тонн нүүрс баяжуулахаар төлөвлөн ажиллаж байна.

1.2 Үйлдвэрийн 2026 оны төлөвлөгөө

2026 онд Нүүрс баяжуулах үйлдвэр нь 7,500 мян.тн тэжээлийн нүүрс баяжуулж 1,562.5 мян.тн баяжуулсан коксжих нүүрс, 2,187.5 мян.тн баяжуулсан сул коксжих нүүрс, 1,650 мян.тн баяжуулсан коксжих чанаргүй нүүрс үйлдвэрлэхээр төлөвлөн ажиллаж байна.

1.3 Баяжуулах үйлдвэрийн усны зарцуулалт

Баяжуулах үйлдвэрийн тэжээлийг нүүрсний давхарга тус бүрийн нүүрсний шинж чанарын үзүүлэлтээс хамааран өөр өөр байхаар төлөвлөсөн учир нүүрсний давхарга бүрийн баяжуулах үйл ажиллагаанд шаарагдах усны зарцуулалт, анхдагч бүтээгдэхүүний чийг, эргэлтийн усны хэмжээ өөр байгааг ус-шлагын тооцоогоор тооцоолсон. Баяжуулах үйлдвэр нь нэг тонн нүүрс баяжуулахад дунджаар 1.91 м³ ус зарцуулах бөгөөд үүний 96.6%

нь өтгөрүүлэгчээс баяжуулах технологид эргүүлэн ашиглах эргэлтийн ус тул үйлдвэрт нэмж өгөх цэвэр ус 3.4% байна.

Баяжуулах үйлдвэрийн усны зарцуулалтын тооцооноос харахад 1 тн нүүрс баяжуулахад шаардагдах нэмэлт усны хэмжээ дунджаар 0.06-0.07 м³ байна. Жилд 10.0 сая.тн нүүрс баяжуулах хүчин чадалтай үйлдвэрийн усны зарцуулалт 30.09- 30.67 л/с бөгөөд жилд 30.0 сая.тн нүүрс баяжуулах хүчин чадалтай үйлдвэрийн усны зарцуулалт дунджаар 91.36 л/с байна.

1.4 Технологийн хаягдлын хэмжээ

Жилд 30.0 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай үйлдвэр жилдээ дунджаар 2.29 сая тонн хаягдал гаргах бөгөөд энэ нь 1.8 т/м³ нягттай гэж тооцвол 1.27 сая/м³ эзлэхүүнтэй байна. Өнөөгийн байдлаар илчлэг багатай хаягдал нь цахилгаан станцын шаардлагыг хангадаггүй, мөн үйлдвэрийн орчимд хаягдлыг барилгын материал, тоосгоны үйлдвэрт борлуулах зах зээлгүй учир бүх хаягдлыг 30 тоннын даацтай тээврийн хэрэгслээр тээвэрлэн Цанхийн зүүн уурхайн хөрсний 2 дугаар овоолгод байршуулж байна. НБҮ нь 2026 онд төлөвлөгөөгөөр 2,556.9 мянган тонн хаягдал 2027 онд 3,423.6 мянган тонн хаягдал хаяхаар урьдчилсан төлөвлөсөн. Цаашид үйлдвэрийн бүхэллэг хаягдлыг тус бүр нь 4000 тн багтаамжтай 2 босоо хаягдлын бункерт хуримтлуулж, хаягдал тээвэрлэх автомашинд автомат ачилтын системээр ачиж Майхан толгой (Майга уул) орчимд байгуулах хаягдлын талбай руу 6.35 км замаар тээвэрлэн овоолго үүсгэн хадгалахаар төлөвлөсөн.

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Уур амьсгал

Цогтцэций сумын уур амьсгал нь манай орны уур амьсгалын эх газарлаг шинж чанарыг бүрэн илэрхийлэх эрс тэс шинжтэй. Өөрөөр хэлбэл сэрүүн бүсийн эх газрын уур амьсгалын эрс тэс эх газарлаг шинж чанарыг илэрхийлсэн тодорхой ялгарсан жилийн дөрвөн улиралтай, өвөл нь хүйтэн, үнэмлэхүй бага температур нь -14.8⁰С хүрдэг, үнэмлэхүй их температур нь 41.3⁰С хүрдэг байна. Хөрсний гадаргын дундаж температур нь ойролцоогоор 8.0⁰С.

Жилийн дундаж агаарын температур нь 0.9⁰С, хамгийн хүйтэн I сарын дундаж температур -14.6⁰С бол хамгийн дулаан сар болох VII сарын дундаж температур 23.1⁰С байдаг байна.

Цогтцэций суманд жилд дунджаар 76.7 мм хур тунадас ордог. Хур тунадасны жилийн явцыг авч үзэхэд зуны улиралд 52.7 мм буюу жилийн нийлбэр хур тунадасны 68 орчим хувь нь унадаг бол үлдсэн хувь нь зунаас бусад улирлуудад унадаг байна.

Салхины зонхилох чиглэлийн хувьд манай ерөнхий зонхилох чиглэл илэрдэг бөгөөд баруун хойноос нийт салхины чиглэлийн 38.8%, баруунаас 20.7%, баруунаас 9.4% давтагдалтай байдаг.

Салхины хурдны олон жилийн дундаж нь ойролцоогоор 5.1 м/с байдаг. Салхины хурдны жилийн явцаас авч үзвэл 4, 5 дугаар сард хамгийн их, харин хүйтний улиралд манай улсын нутагт төвтэй эсрэг циклон оршдог тул салхины хурд багасдаг боловч зарим жил 34 м/с хүрч шороон болон цасан шуурга шуурч байсан тохиолдол цөөнгүй.

2.2 Геоморфологи

Гадаргуугийн хувьд ерөнхийдөө нам уулс, жижиг толгод, талархаг гадаргуу зонхилох ба далайн түвшнээс дээш 1490-1590 м өргөгдсөн. Хамгийн өндөрлөг цэгүүд нь Таван толгойн талбайгаас баруун урагш орших Бага уул /1731.1 м/, зүүн хойно байх Майга улаан

уул /1587.5 м/, чанх урагш орших Нэргүй өндөрлөг /1652.2 м/, зүүн урагш байх Таван толгой уул /1570 м/ зэрэг болно. Хамгийн нам цэгүүдэд Улаан нуур болон бусад нуур тойрмуудын хөндий орно. Голын хөндийнүүд нь ерөнхийдөө өргөргийн чиглэлтэй ба элсэрхэг, шаварлаг хурдсаар дүүргэгдсэн байдаг. Физик газар зүйн мужлалаар цөлийн ландшафттай говийн мужид хамаарах бөгөөд газар зүйн хэлбэр, гадаргуугийн хэв шинжээр цав толгод, ухаа гүвээт талын хэв шинжид багтана.

Гадаргуу нь гарал үүслийн шинж чанараа денудацийн буюу зөөгдлийн, структур-денудацийн, эрози-денудацийн буюу элэгдэл-зөөгдлийн, денудаци-хуримтлалын бүрдэлд хуваагддаг.

2.3 Хөрсөн бүрхэвч

Хөрс газарзүйн мужлалаар хөрс био-уур амьсгалын өргөргийн бүсчлэл бүхий Говийн мужийн Говийн цайвар бор, Цөлийн бор саарал хөрс бүхий 12-р тойрогт (Манлайн хөрсний тойрогт) багтана. Говийн цайвар бор зонхилон тархах бөгөөд урд хэсгээр Цөлийн бор саарал хөрстэй. Ерөнхий хөрсөн бүрхэвч нь доворхог хад чулуурхаг газрын гадаргын байдлаас шалтгаалж алаг цоог, хоршил зонхилно. Өндөрлөг газраар нимгэн чулуурхаг, хотгордуу газраар ердийн Говийн цайвар бор хөрстэй. Лицензийн талбайн хойд хэсгээр нимгэн чулуурхаг хөрстэй байхад, урд хэсгийн хотгордуу газраар элсэрхэг дов ихтэй элэгдэл эвдрэлд амархан өртөмтгий сийрэг элсэн хөрс нэлээд их талбай эзэлж байна. Хотгордуу газраар мараалаг хужирлаг шинжийн давсархаг хөрс хам бүрдэл үүсгэж бага зэрэг талбай эзэлнэ.

2.4 Ургамлан нөмрөг

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг нь ландшафт-экологийн мужлалаар Дундад говийн муж, Даланзадгадын районд гүвээ толгод бүхий уудам хөндий, хужир марзтай хотгор, цөлөрхөг хээрийн ургамал зонхилсон газар юм. Ургамлан нөмрөг нь газрын гадаргын байдал, хөрсний бүтэц, усан хангамжаас шалтгаалан таана-баглуурт, таана-хялгана, бор бударгана, улаан бударгана зэрэг эвшил бүлгэмдлээс бүрдэх бөгөөд алтан харгана, дэрс, загсгал, догар, хотир зэрэг сөөг олон наст болон нэг наст өвслөг ургамлууд оролцдог байна. Нийтдээ 13 овгийн 51 төрлийн 75 зүйлийн бүрдэлтэй байна.

2.5 Нийгэм, эдийн засаг

Үйлдвэртэй хамгийн ойр орших суурин газар нь Цогтцэций сум юм. Тус сум нь Монгол улсын өмнөд хилээс 240 км, аймгийн төвөөс 100 км, нийслэл Улаанбаатар хотоос 540 км-т алслагдсан бөгөөд өмнө талаараа Баян-Овоо, баруун талаараа Ханхонгор, хойд талаараа Цогт-Овоо, Дундговь аймгийн Өлзийт сумтай, зүүн талаараа Манлай сумтай тус хил залгана.

2025 оны жилийн эцсийн урьдчилсан байдлаар Цогтцэций сум нийт 11139 хүн амтайгаас Сийрст багт 2674, Билгэх багт 2905, Цагаан-Овоо багт 2555, Өгөөмөр багт 3005 хүн ам тус тус бүртгэлтэй байна.

Хүснэгт № 1. 2025 оны 12 сарын 31-ний хүн амын тоо

Үзүүлэлт	Өмнөговь аймаг	Цогтцэций сум
Хүн амын тоо	78931	11139
Эрэгтэй	39439	5640
Эмэгтэй	39492	5499

Өмнөговь аймаг нь 2025 оны 12 сарын 31-ний байдлаар 15 сумын 59 багт 2.3 сая толгой мал тоолуулснаас Цогтцэций суманд 158.5 мян толгой мал тоологдсон байна.

Хүснэгт 1. 2025 оны мал тоо /мян.тол/


Аймаг, сум	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Өмнөговь	2.295,2	105.2	33.0	155.9	623.8	1377.2
Цогтцэций	158.5	11.3	2.5	4.3	60.3	80.1

Цогтцэций сум нь Өмнөговь аймгийн 15 сум дотроо хамгийн бага буюу 700 гаруй га газар нутагтай. Түүний 16% нь ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй. Үүнээс төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК, “Энержи Ресурс” ХК нь Тавантолгойн бүлэг ордод идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр төсөл жилдээ 20 сая тонн нүүрс олборлон экспортолж байна. Мөн хөрс хуулалт, тээврийн үйл ажиллагаанд 20-30 туслан гүйцэтгэгч гэрээт компаниуд оролцон үйл ажиллагааны эрчимд нөлөөлж байдаг.

2.6 Төслийн талбайн байршил

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн нутаг дэвсгэрт хэрэгжинэ.

Зураг № 1. Хаягдлын талбай байгуулахаар төлөвлөсөн байршил



3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн захиалгаар “Газар дэлхий” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн “Нүүрс баяжуулах үйлдвэрийн хаягдлын талбайн төсөл”-ийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан (цаашид БОННУ гэх) -д тусгасан төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээг баримталлаа.

“Тавантолгойн нүүрс баяжуулах үйлдвэрийн хаягдлын талбай төсөл”-ийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй шууд нөлөөлөл 9, шууд бус нөлөөлөл 6 байна. Нийт нөлөөллийн 5 нь бага эрчимтэй, 10 нь дунд эрчимтэй, 2 нь хүчтэй нөлөөлөлд хамрагдаж

байна. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нийт нөлөөлөл нь шууд, дундаас урт хугацааны, дунд зэргийн нөлөөлөл байна.

3.1 Эрсдэлийн үнэлгээг эрсдэлийн матриц

ISO 14001:2015 стандартын дагуу байгаль орчны гүйцэтгэлийн ач холбогдлын дарааллыг тодорхой болгох зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийсэн. Байгаль орчны асуудлыг тодорхойлж эдгээртэй холбоотой байгаль орчны нөлөөллийг тодорхойлсон. Нөлөөлөл тус бүрийн эрсдэлийн зэргийг тодорхойлсон.

Хүснэгт № 2. Эрсдэлийн үнэлгээний матриц

Магадлал	Үр дагавар				
	ялимгүй	бага	дунд	их	гамшиг
I бараг болохгүй	L	L	M	H	H
II магад болохгүй	L	L	M	H	E
III болзошгүй	L	M	H	E	E
IV магад болох	M	H	H	E	E
V лавтай болох	H	H	E	E	E

Хүснэгт № 3. Магадлалын үнэлгээний шалгуур

Түвшин	Зэрэг	Тайлбар
I	Бараг болохгүй	Онцгой нөхцөлд эрсдэлтэй байж магадгүй (<5%)
II	Болохгүй байж магад	Заримдаа эрсдэлтэй байж магадгүй (5-20%)
III	Болзошгүй	Заримдаа эрсдэл үүснэ (20-50%)
IV	Магад болох	Бараг бүх нөхцөл эрсдэл үүсгэж болзошгүй (50-70%)
V	Лавтай болох	Бараг бүх нөхцөл эрсдэлтэй (70-100%)

Хүснэгт № 4. Үр дагаварын үнэлгээний шалгуур

Зэрэглэл	Уршиг	Эрсдэлд өртөгч ба эрсдэлийн тодорхойлолт		Уршигийг бууруулах арилгах шийдэл
		Хүн ам	Эд хөрөнгө	
I	Ялимгүй	Техноген нөлөө арилахад хор уршиг арилна	Хохирол үгүй	Тусгай шийдэл шаардлагагүй
II	Бага	Бүс нутагт хуримтлагдах нөлөөлөл бий болгож био орчинд стресс учруулна	Багавтар хохирол	Уламжлалт арга хэмжээ, одоогийн горимыг мөрдөх
III	Дунд	Урт хугацаанд дэлхийн дулааралд хувь нэмэр оруулна	Дунд зэрэг хохирол	Уламжлалт арга хэмжээ, одоогийн чанд горимыг мөрдөх, зохион байгуулалтын өндөр түвшинд ажиллах
IV	Их	Хуримтлагдах сөрөг нөлөө үүсгэж урт хугацаанд экологийн тэнцвэр алдагдана	Их хохирол	Орчин үеийн технологи, өндөр сонор сэрэмж, зохион байгуулалтын хоршил, Тодорхой хэмжээний хөрөнгө зардал шаардана
V	Гамшиг	Байгаль орчинд эргэж буцахааргүй уршиг учруулж экологийн тэнцвэрт байдал алдагдахад хүрнэ	Маш их хохирол	Орчин үеийн технологи, өндөр сонор сэрэмж, зохион байгуулалтын хоршил. Их хэмжээний хөрөнгө оруулалт шаардана

Хүснэгт № 5. Төслийн болзошгүй нөлөөллийн хэлбэр,
үргэлжлэх хугацаа, эрчим

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Дунд хугацааны	Урт хугацааны	Будаж нөлөөлөх	Буцалтгүй	Бага зэрэг	Дунд зэрэг	Хүчтэй
1. Байгалийн экосистемийн өөрчлөлт											
Газрын доорх усны урсац, горим, чанарт өөрчлөлт гарах		x				x				x	
Хаягдлын талбайн үйл ажиллагаанаас ургамлын бүлгэмдэл, бүтцэд өөрчлөлт орох, талхлагдах		x				x		x		x	
Хаягдлын талбайн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвч элэгдэх, эвдрэлд орох, дарагдах	x					x		x			x
Хүн, машин техникийн хөдөлгөөн, газар шорооны ажилтай холбоотойгоор ойр орчимд нутагладаг ан амьтдын амьдрах орон зай өөрчлөгдөх		x			x			x		x	
Уур амьсгалын /бичил/ өөрчлөлт		x		x			x		x		
2. Байгалийн нөөц, ашиглалт											
Газрын гадаргын ашиглалт	x			x				x			x
Газрын доорх усны ашиглалт	x				x					x	
Бэлчээрийн газрыг ашиглах	x			x				x		x	
Эрдэс түүхий эдийн нөөц	x			x				x	x		
Эрчим хүчний нөөц			x		x				x		
3. Байгаль орчны чанарын өөрчлөлт											
Шатах тослох материалын хэрэглээ, хог хаягдал хадгалалт, зайлуулалттай холбоотойгоор газрын доорх ус бохирдох		x			x		x		x		
Гадаргын усны бохирдол			x				x			x	
Хаягдлын талбайн үйл ажиллагаанд өртөж буй талбай болон зам зэрэг гадаргуугаас тоос босох, тээврийн хэрэгслийн хөдөлгүүр дэх шаталтаас үүсэх хорт хий зэргээс агаар бохирдох	x			x			x			x	
Шатах тослох материалын хэрэглээ, хог хаягдал хадгалалт, зайлуулалттай холбоотойгоор хөрс бохирдох	x				x			x		x	
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор											

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Дунд хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй	Бага зэрэг	Дунд зэрэг	Хүтэй
Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	x					x		x		x	
Ландшафтын хэлбэр өөрчлөгдөх	x					x		x		x	
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх	0										
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх	0										
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх	0										
5. Эдийн засаг, нийгмийн асуудал											
Орон нутгийн орлого нэмэгдэх	+			+							+
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	+			+							+
Ажлын байр нэмэгдэх	+			+							+
Хаягдлын талбайн хэрэгцээг дагаад орон нутгийн үйлчилгээний байгууллагын эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+			+							+
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		x			x				x		
Нийт (сөрөг/ээрэг)	9/4	6	2	5/4	6	5	4	9	5	10	2/4

3.2 Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ

Газрын гадарга ба хэвлий, хөрс, ургамлан бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ

- Хаягдлын талбайн үйл ажиллагааны үед аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдөх, технологийн буруу ажиллагаанаас үүдэн хөрсний нуралт, гулгалт зэрэг осол аваар үүсэж болзошгүй;
- Төсөл хэрэгжүүлэгч нь “Газар хөндөх зөвшөөрөл олгох журам” баталж мөрдүүлээгүйн улмаас уурхайн талбайн болон түүний эргэн тойронд эмх замбараагүй газар ашиглалт явагдаж болзошгүй;
- Төслийн үйл ажиллагаанд хэрэглэж буй үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай химийн бодисууд ямар нэгэн байдлаар асгарснаар газрын хэвлий болон түүний гадарга, хөрс ба ургамлын нөмрөгийг бохирдуулж болзошгүй;
- Хаягдлын тээвэрлэлтийн үед их хэмжээний тоос дэгдэж ургамлын бүрхэвчид сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй;
- Хүний буруутай үйл ажиллагаа болон аюулгүй ажиллагааны дүрмийг чанд баримтлан ажиллаагүйн улмаас объектуудад осол-аюул гарснаар газрын гадаргад ноцтой аюул, гамшиг, бохирдол үүсгэж болзошгүй;
- Шатах тослох материалыг тээвэрлэх, юүлэх, хадгалалтын горим алдагдах үед асгаралт үүсэж газрын гадарга хэвлийг бохирдуулах магадлалтай, машин, техникийн ашигласан тосыг буруу хадгалах зэрэг шалтгаанаас үүдэн алдагдан газрын гадарга бохирдуулж болзошгүй;
- Төслийн ахуйн гаралтай хог хаягдлын цэгийг зохих стандартын дагуу байгуулаагүй, хог хаягдлыг зохих дүрмийн дагуу зайлуулж, устгаагүйн улмаас салхи, усаар зөөгдөн ойр орчмын газрын гадаргыг бохирдуулж болзошгүй;

- Ахуйн гаралтай хатуу, шингэн хог хаягдлын зохих дүрмийн дагуу зайлуулаагүйн улмаас газрын гадарга бохирдож болзошгүй.
- Төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй тоосжилт, талхагдлын нөлөөгөөр тухайн орчны ургамлан нөмрөгийн үндсэн хэв шинж өөрчлөгдөх, бүрхэц, биомасс буурах, зүйлийн олон янз байдал алдагдах, хөл газрын ургамлын төрөл зүйл нэмэгдэх зэрэг сөрөг нөлөөллүүд гарч болзошгүй.
- Төслийн үйл ажиллагаа эхэлснээр олон машин техник ашиглагдах учир эдгээр олон машин техникийн хөдөлгөөнөөр төслийн талбайн орчмын хөрс ургамлан нөмрөг талхлагдах, олон салаа үүсэх зэргээр тухайн орчны бэлчээр ургамлан нөмрөгт сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй.

Агаар орчин

- Хаягдлын талбайн үйл ажиллагааны үед гарч болзошгүй галын аюул, осол аваарын үед гарах хорт хийн дэгдэлт агаарын чанарт сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй;
- Хаягдлын талбайн үйл ажиллагааны үед үүсэх тоосны тархалт төсөл хэрэгжиж буй нутгийн агаарын чанарт бохирдол үзүүлж болзошгүй.
- Хаягдлын талбайн үйл ажиллагааны үед үүсэх тоосны тархалт төсөл хэрэгжиж буй нутгийн агаарын чанарт бохирдол үзүүлж болзошгүй.

Гадаргын болон газрын доорх ус

- Хаягдлын талбай байгуулах малталтаас үүдэн тухайн нутгийн газрын доорх ус агуулагч бүрдэл хурдасны зүй тогтол өөрчлөгдөж болзошгүй;
- Төслийн үйл ажиллагааны үед гарч буй хаягдал бохир ус болон, шатах, тослох материалын хаягдлаар ус бохирдож болзошгүй.

Амьтны аймаг

- Шөнийн цагаар үйл ажиллагаа явагдсан нөхцөлд шөнийн амьдралтай амьтдад сөрөг нөлөөлөл учруулна. Дуу чимээ, гэрэл гарч, амьтад дайжих, махчин амьтад идэш тэжээлээ барих зэрэгт нөлөөлнө;
- Хаягдлын талбайтай холбоотой аливаа тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас амьтдын аймаг, тэдгээрийн амьдралын зүй тогтолд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй;
- Болзошгүй галын аюул, осол аваарын үед гарах үнсний дэгдэлт, хорт утааны тархалтад амьтад хордож болзошгүй зэрэг болно.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

“Газар дэлхий” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн “Нүүрс баяжуулах үйлдвэрийн хаягдлын талбайн төсөл”-ийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын хүрээнд тухайн төслийн хэрэгжилтийн явцад авч хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав. Мөн “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 58 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам” болон уг төслийн БОННУ-г үндэс болгов.

Энэхүү төлөвлөгөөний зорилго нь тухайн төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, бохирдлоос сэргийлэх, ерөнхий үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх, байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийг төлөвлөх, хэрэгжилтийн үр дүнг тогтооход оршино. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдсэн.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Бүлэг	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Нийт зардал, ₮	Эрх зүйн баримт бичиг
1	Хаягдлын овоолго байгуулах ажилд ашиглагдах машин механизмаас ялгаран гарах хорт хий орчны агаарыг бохирдуулах	Тус ажилд ашиглагдаж буй бүх төрлийн машин механизмыг үзлэг оношилгоонд тогтмол хамруулж, холбогдох засварыг хийж, стандартын шаардлагад нийцүүлж байх	Хаягдлын овоолго байгуулах ажилд ашиглагдаж байгаа бүх төрлийн машин техник	10ш	Жилд 1 удаа	1,000,000	MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин-Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин-Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга

Бүлэг	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Нийт зардал, ₮	Эрх зүйн баримт бичиг
2	Хаягдал тээврийн сайжруулсан шороон замаас тоос дэгдэж хүрээлэн буй орчинд тархах	Хаягдал тээврийн үед үүсэх тоосжилтыг дарахын тулд тогтмол хуваарийн дагуу усалж байх	НБҮ-рүү салдаг хатуу хучилттай замаас хаягдлын талбай хүртэлх 3.97 км сайжруулсан шороон зам	-	Хуурайшилтын улиралд өдөр бүр бусад үед цаг уурын нөхцөлөөс хамаарна	Үйл ажиллагааны зардал	Агаарын тухай хууль 9, 11, 23-р зүйл Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага MNS4585:2025
3	Төслийн нөлөөгөөр орчны үржил шимт хөрс, ургамлан бүрхэвч бүхий талбай хүнд даацын машин техникийн үйл ажиллагааны нөлөөнд өртөж, хөрсний элэгдэл, эвдрэл үүсэж ургамлан бүрхэвч сөрөг нөлөөлөлд өртөх	Хаягдал тээврийн замыг тэмдэгжүүлэх, олон салаа зам гаргуулахгүй байхад хяналт тавих		5 ш	Сайжруулсан шороон зам тавих үед	250,000	Газрын тухай хууль 50-р зүйл
4		Хаягдлын овоолгуудын дор орох талбайн үржил шимт хөрсийг (20-25 см) хуулан авч тусад овоолго үүсгэн холбогдох стандартын дагуу хадгалах	Хаягдлын талбайд	55 га	Овоолго тус бүрийг байгуулж эхлэхийн өмнө	Үйл ажиллагааны зардал	MNS 5916:2008 Байгаль орчин, Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт
5	Хаягдлын овоолгуудаас үүсэж болзошгүй хүчиллэг урсац хөрсний усыг бохирдуулах	Бүхэллэг болон нунтаг хаягдлаас улирал тутам төлөөлөх чадвартай дээж бүрдүүлж, хүчиллэг урсацын багц үзүүлэлтийг тодорхойлуулах	Хаягдлын дээж	8 дээж	Улиралд 1 удаа 2 төрлийн хаягдлаас	Үйл ажиллагааны зардал	Усны тухай хууль
	Нийт					1,250,000	

6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бүлэг	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Нийт зардал, ₮	Эрх зүйн баримт бичиг
1	Нүүрс баяжуулах үйлдвэрийн цаашид барилгажихгүй талбайд	Техникийн нөхөн сэргээлт	Үйлдвэрийн барилгын ухлагаас гарсан шороог хаягдлын талбайн суурийн дэвсгэлтэнд ашиглах	м³	1500	2026 оны 2-р улиралд	2,750,000	МУ-ын Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, 2012
2		Биологийн нөхөн сэргээлт	Мод тарих	ш	200	Бүх нийтийн мод тарих өдөрлөг	2,000,000	Газрын тухай хууль 2002 MNS 5917:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн стандарт
Нийт							4,750,000	

7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг	Нийт зардал, ₮
1	Соёлын өвийн талаар мэдээлэл түгээх	Соёлын өвийн талаарх сургалт зааварчилгаа өгөх	Ажил гүйцэтгэж байгаа ажилчид	Жилдээ	Соёлын өвийн тухай хууль	600,000
Нийт						600,000

8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төлөвлөгөөнд БОННУ-нд тусгагдсан Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг оруулан боловсруулсан болно.

Бүлэг	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Зарцуулах зардал ₮	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Цаг агаарын улирлын, сарын, 7 хоногийн, өдөр тутмын урьдчилсан мэдээнүүдийг төслийн үйл ажиллагаанд тогтмол ашиглах	Хаягдлын талбай	Өдөр	365	-	Тухай бүр	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль
2	НБҮ-ийн байранд анхны тусламж үзүүлэхэд нэн шаардлагатай хэрэгслүүдийг байрлуулах	Нүүрс баяжуулах үйлдвэр	Жилдээ	1	2,000,000	Тухай бүр	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
3	Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах	Хаягдлын талбай	Удаа	4	-	Дотоод төлөвлөлтийн дагуу	Галын аюулгүй байдлын тухай хууль
4	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих, сургалт зохион байгуулах	Хаягдлын талбай	Өдөр	365	3,000,000	Тухай бүр	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
5	Ажиллагсдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	Ажилчид	Удаа	2	Үйл ажиллагааны зардал	Жил бүр	

Бүлэг	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Зарцуулах зардал ₮	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
6	Ослын үеийн хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж сумын захиргаа болон орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагаар батлуулах	Хаягдлын талбай	Удаа	1	Үйл ажиллагааны зардал	Жил бүр	
7	НБҮ-ийн байранд анхны тусламж үзүүлэхэд нэн шаардлагатай хэрэгслүүдийг байрлуулах	Хаягдлын талбай	Удаа	1	1,000,000	Жил бүр	
8	Химийн бодисын ХАЛМ-ийн мэдээллийн сан бүрдүүлэх, Химийн бодисын хор, аюулын ангиллын мэдээллийн санг монгол хэлээр боловсруулж, цаасан болон цахим хэлбэрээр бүрдүүлэн нийт ажилтанд нээлттэй ашиглуулах	Нэгж, хэсэг, химийн лабораторийн бүх ажилтан, нэгж, хэсгийн удирдлага	Удаа	2	1,000,000	Жил бүр	Хуулийн 4 дүгээр зүйл, “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”
9	Химийн бодистой харьцан ажилладаг ажилтнуудын аюулгүй ажиллагааны мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор дотоод сургалтыг тогтмол зохион байгуулж, үр дүнг үнэлэн, шаардлагатай тохиолдолд давтан сургалт явуулна.	Нэгж, хэсэг, химийн лабораторийн бүх ажилтан, нэгж, хэсгийн удирдлага	Удаа	1	1,000,000	Жил бүр	Хуулийн 13.4 Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”

Бүлэг	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Зарцуулах зардал ₮	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
10	Ажлын байрны онцлогт нийцүүлэн тусгай асуулга бүхий хуудсаар нэгж, хэсгийн ажилтнуудаас тодорхой давтамжтайгаар шалгалт авч дүгнэж, үнэлэх	Нэгж, хэсэг, химийн лабораторийн бүх ажилтан, нэгж, хэсгийн удирдлага	Удаа	1	Үйл ажиллагааны зардал	Жил бүр	Хуулийн 8.2 Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”
11	Ашиглагдаж буй химийн бодисын ашиглалт, зарцуулалтын бүртгэлийг бодис тус бүрээр, нэгж/хэсэг бүрээр цахим хэлбэрт шилжүүлэн хөтөлж, хөдөлгөөний нэгдсэн тайлан гаргах	Нэгж, хэсэг, химийн лабораторийн бүх ажилтан, нэгж, хэсгийн удирдлага	Удаа	12	Үйл ажиллагааны зардал	Сар бүр	Хуулийн 13.7
12	Агуулахын үлдэгдэл нөөц, ашиглалтын хугацаанд үндэслэн химийн бодисын хэрэгцээг оновчтой тооцоолж, дараа жилийн худалдан авалт, хэрэглээний төлөвлөлтийг боловсруулах	Нэгж, хэсэг, химийн лабораторийн бүх ажилтан, нэгж, хэсгийн удирдлага	Удаа	1	Үйл ажиллагааны зардал	Жил бүр	Хуулийн 13.7
13	“Химийн хорт болон аюултай бодисын менежмент, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа” богино хугацааны төрөлжсөн сургалтад химич, химийн инженерүүдийг ээлжлэн сургаж мэргэшүүлэх	Химийн лабораторийн бүх ажилтан,	Удаа	1	3,000,000	Жилдээ	Хуулийн 8.1; 8.2; 13.6
	Нийт				11,000,000		

9. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бүлэг	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Зарцуулах зардал, ₮	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Барилга	Хаягдлын талбайгаас гарах хог хаягдлыг батлагдсан журмын дагуу ангилан ялгаж зайлуулах	Барилгын ажил явагдаж буй талбай	Үүссэн хэмжээгээр	Тухай бүр	1,800,000	Хог хаягдлын тухай хууль, 2017
2	Энгийн	Ахуйн гаралтай хог хаягдлыг ангилан ялгаж хогийн цэг рүү ачуулах арга хэмжээ авах	Нүүрс баяжуулах үйлдвэр болон хаягдлын талбай	12 удаа	Тухай бүр	1,200,000	“Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам”, 2018
3		Хог хаягдлын хураамжийг төвлөрүүлэх		Үүссэн хэмжээгээр	Үйл ажиллагааны турш	600,000	
Нийт						3,600,000	

10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Бүлэг	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, ₮	Баримтлах стандарт, арга, аргачлал
10.1 Агаарын чанар							
1	Аэрозол: PM2.5, PM10, нийт тоосонцор	2 цэг	4, 10-р сар	Жилд 2 удаа	1,500,000	MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага	
2	Агаарын найрлага дахь SO ₂ , NO ₂ хийнүүдийг хэмжилт	3 цэг	3, 8-р сар	Жилд 2 удаа	2,250,000		
10.2 Хөрсөн бүрхэвч							
1	Хөрсөн дэх хүнд металлын агууламж	4 цэг	6-8 сард	Жилд 1 удаа	1,800,000	MNS 3298:1990 Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд, MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ	
2	Агрохими	4 цэг	6-8 сард	Жилд 1 удаа	1,800,000		
10.3 Газрын доорх ус							
1	Бохир усны шинжилгээ /Ажилчдын амрах байр/	1 цэг	3,6,8,10	Улиралд 1 удаа	1,000,000	MNS 4943:2015	
10.3 Ургамлан нөмөг							
1	Ургамлын мониторинг хийх /зүйлийн бүрдлийг тодорхойлох/	2 цэг	9 сард	Жилд 1 удаа	600,000		
Нийт					8,950,000		

11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бүлэг	Төлөвлөсөн арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, ₮	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Хариуцах нэгж
1	Байгаль хамгаалах ажлын барьцаа хөрөнгө төвлөрүүлэх	Тухайн жилийн БОМТ-д тусгасан зардал	Үйл ажиллагааны зардал	Жил бүр	Байгаль орчны асуудал хариуцсан нэгж
2	Жил бүрийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г боловсруулж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах	Үйл ажиллагааны хүрээнд	Үйл ажиллагааны зардал	Төслийн БОННУ-г төрийн захиргааны төв байгууллагаар батлуулснаас хойш 1 сарын дотор боловсруулах, цахимаар илгээж батлуулах	Байгаль орчны асуудал хариуцсан нэгж

12. НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Бүлэг	Оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа	Нийт зардал, ₮	Хариуцах нэгж	Зохион байгуулах газар
1	Багийн иргэд	Танилцуулга хийх	2026 оны БОМТ-ний биелэлт	2026 оны 12 сар	300,000	Холбогдох хэлтэс нэгж	НБҮ
					300,000		

13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨВ

№	БОМТ ангилал	Төсөв ₮
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	1,250,000
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	4,750,000
3	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	600,000
4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	11,000,000
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	3,600,000
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	8,950,000
7	Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө	-
8	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	300,000
Нийт		30,450,000